*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт*

# САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГА Л.ЛУВСАНГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## 1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| НЭГ: ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО | | | | | | | |
| .1. Эрүүл мэнд. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна. | | | | | | | |
| 1.1.1 | ЗГҮАХ 1.1.3.2, МУТЖҮЧ-2.2.1 МУХТ 1.1.3 Шаардлагатай аймгуудад ЗӨСТ, хил дагуух боомтод тандалтын нэгж байгуулна. | Байгуулсан ЗӨСТ болон хил дагуух боомтод байгуулсан тандалтын нэгжийн тоо | Тооцоо, судалгаа хийгдсэн. | Говь-Алтай аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн барилга ашиглалтад оруулна Өмнөговь аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн барилгын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулж, барилгын ажлыг эхлүүлсэн байна. Хил дагуух боомтод | ЭМС-ын 2024 оны А/238 тушаалаар АХБ-ны “Цар тахлын эсрэг шуурхай арга хэмжээ авах эрүүл мэндийн тогтолцооны чадавхыг бэхжүүлэх” МОН-9218 төслийн хүрээнд нийлүүлэгдсэн 2,88 тэрбум төгрөгийн молекул биологийн лабораторийн тоног төхөөрөмжийг ЗӨСҮТ болон 14 салбар ЗӨСТөвд хуваарилж, хүний нөөцийг чадавхжуулах сургалт зохион байгуулсан. | II, IV улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | тандалтын нэгж байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангасан байна. | | | |
| 1.1.2 | Эрт илрүүлгийн явуулын машины ашиглалтын журам батлуулна. | Батлагдсан тушаал | | Хамарах чиг үүргийн судалгааг гаргасан байна. | Нийтийн эрүүл мэндийн газартай хамтран Эрүүл мэндийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 01-ны өдрийн А/96 дугаар "Түр журам батлах тухай" тушаал батлуулсан. Уг тушаалаар урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ хийх тусгай зориулалтын автомашиныг ашиглах түр журам, автомашин, түүнд суурилагдсан багаж төхөөрөмжийг хүлээлцэх багийн бүрэлдэхүүн, хяналтын хуудасыг баталсан. | I-II, улирал | 100% |
| 1.1.3 | ЗГҮАХ 2.1.3.1<br>Эрхтэн шилжүүлэн суулгах үндэсний төв | Барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн хувь | - | Ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, барилга угсралтын ажлыг эхлүүлсэн байна. | Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд "Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төв /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/" төсөвт өртөг нь 140.0 тэрбум төгрөг, санхүүжих дүн нь 42.0 тэрбум төгрөгөөр батлагдсан. Төрийн Худалдан авах ажиллагааны газраас худалдан авах ажиллагаа зарлан гүйцэтгэгчээр "Магнуссентурион Констракшн" ХХК болон "Сетунари" ХХК-ийн түншлэл шалгаран 140.0 тэрбум төгрөгийн гэрээ байгуулсан. Газар шороо, гаражийн барилгын суурь, 1 давхарын цутгалтын ажил хийгдэж байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 10%-тай байна. | I-IV улирал | 100% |
| 1.1.4 | ЗГҮАХ 2.1.3.2<br>Зүрх судасны төв байгуулна. | Зүрх судасны төвийн гадна инженерийн шугам, сүлжээний барилга угсралтын | Батлагдсан ТЭЗҮ | Ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, барилга угсралтын ажлыг эхлүүлсэн байна. | Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд "Зүрх, судасны үндэсний төвийн барилгын гадна инженерийн шугам, сүлжээ /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 5 дугаар хороо/" төсөвт өртөг нь 2.3 тэрбум төгрөг, санхүүжих дүн нь 1.1 тэрбум төгрөгөөр батлагдсан. Төрийн Худалдан авах ажиллагааны газраас худалдан авах ажиллагааг 7 удаа зарласан, 5 удаа | I-IV улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | ажлын гүйцэтгэлийн хувь | | | оролцогч санал ирүүлээгүй 2 удаа шаардлага хангасан оролцогч санал ирүүлээгүй.<br>ЕСБХБанкны хөнгөлөлттэй зээлээр “Зүрх судасны үндэсний төв”-ийн барилгын төслийг санхүүжүүлэхээр 2024.09.30-ны өдөр МУ-ын ЭЗХЯам, СЯ, ЭМЯ болон ЕСБХБанк хамтарсан DTM55677 дугаартай “Санхүүжилтийн өмнөх гэрээ”-г байгуулсан. Уг гэрээний дагуу 120 ортой тусгай зориулалтын ЗСҮТөвийн барилга барьж ашиглалтад оруулах төслийн нийт өртөг 51,0 сая ам.доллар байх ба ЕСБХБанк нь 30,0 сая ам.долларыг хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлнэ. Тоног төхөөрөмжийн нийт өртөг 21,0 сая ам.доллар байх ба улсын төсөв болон Люксембургийн Их Гүнт улсын буцалтгүй тусламжаар санхүүжүүлэхээр тооцоолсон. Мөн ЕСБХБанкны “Техникийн хамтын ажиллагааны сан”-аас төслийн “Техник эдийн засгийн үнэлгээ”, –“Байгаль орчин, нийгмийн үнэлгээ”, “Худалдан авалтын үйл ажиллагаанд түр хугацааны дэмжлэг үзүүлэх”, “Төслийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих” зэрэг үйл ажиллагаанд 1,1 сая еврогийн буцалтгүй тусламжийг үзүүлнэ. | | |
| 1.1.5 | ЗГҮАХ 2.1.3.4 Геронтологийн төвийн барилгын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулна. | Барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн хувь | 80% | Барилга угсралтын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулсан байна. | Барилга угсралтын ажлын зураг төсөл, төсвийг бүрэн болгож, Барилгын хөгжлийн төвийн магадлалаар баталгаажуулахад төсөвт өртөг нь нэмэгдсэн. Төсөвт өртгийн нэмэгдлийг шийдвэрлүүлэхээр Монгол Улсын 2022, 2023 оны төсвийн тухай хуульд тусгуулахаар Улсын Их Хурал, Сангийн яаманд хүргүүлсэн боловч хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлэгдээгүй. Иймд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа “Сэргээн засах төвийн барилга, 36 ор /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 10 дугаар хороо/”-ын ажлыг | I-IV улирал | 95% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дуусган Геронтологийн төв болгон ашиглахаар төлөвлөж байна. Ажлын гүйцэтгэл 95%-тай явж байгаа бөгөөд улсын комисс ажиллуулах хүсэлтээ өгсөн. 2024 оны 12 дугаар сарын 2 дугаар 7 хоногт ажиллах улсын комиссын хуваарьт оруулахаар ажиллаж байна. | | |
| 1.1.6 | ЗГҮАХ 2.1.3.6<br><br>Халдварт өвчин судлалын үндэсний төвийн цогцолбор салбар II байгуулна. | Гадна инженерийн шугам, сүлжээний барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн хувь | Батлагдсан ТЭЗҮ | Ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, барилга угсралтын ажлыг эхлүүлсэн байна. | Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд "Халдварт өвчин судлалын үндэсний төв-2"-ийн гадна инженерийн шугам, сүлжээ /Төв, Сэргэлэн сум/ байгуулахаар төсөвт өртөг нь 13.3 тэрбум төгрөг, санхүүжих дүн нь 4.0 тэрбум төгрөгөөр батлагдсан. Төрийн Худалдан авах ажиллагааны газраас худалдан авах ажиллагааг зарлан гүйцэтгэгчээр “Эм Си Эс Си” ХХК болон “Солармед Монгол” ХХК-ийн түншлэл шалгаран гэрээ байгуулсан. Газар, шорооны ажил хийгдэж байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 5%-тай байна. | I-IV улирал | 100% |
| 1.1.7 | ЗГҮАХ 2.1.3.7<br><br>Хавдар судлалын үндэсний төвийн салбар II байгуулна. | Барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн хувь | - | Ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, барилга угсралтын ажлыг эхлүүлсэн байна. | Хавдар судлалын үндэсний төв-2 цогцолбор байгуулах зориулалтаар Баянзүрх дүүргийн 11 дүгээр хорооны Чулуутын аманд 10 га газар олгогдож, зураг төслийг БХБЯаманд захиалж, 2021 оноос зураг төсөл, төсөв боловсруулах гэрээ байгуулагдсан боловч, зургийн ажлын явц 30 хувьтай байна.<br>Ажлын зураг төсөл, төсвийн гүйцэтгэгч "Хот Төлөвлөлтийн Хүрээлэн" ХХК 996.0 сая төгрөгийн гэрээ байгуулсан боловч загвар зураг батлагдсаны дараа тухайн гэрээний дүнгээр гүйцэтгэх боломжгүй 3,800.0 сая төгрөгөөр гүйцэтгэх тухай санал ирүүлж, зөвшөөрөхгүй тохиолдолд гэрээ цуцлах хүсэлт гаргасан. Гүйцэтгэгчийн саналыг захиалагч Барилга, хот байгуулалтын яамнаас судлан 3,800.0 сая төгрөг биш нэмэлт 3,000.0 сая төгрөг шаардлагатай гэсэн тооцоолол гарган санхүүжилтийн эх | I-IV улирал | 80% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үүсвэрийг шийдвэрлүүлэхээр Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад хандсан. 2024 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн "Жагсаалт батлах тухай" А/12 дугаар тушаалаар нэмэлт хөрөнгө шийдвэрлэж, Эрүүл мэндийн яамнаас худалдан авах ажиллагааг зарлуулахаар Төрийн Худалдан авах ажиллагааны газарт холбогдох мэдээллийг 2024 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 2/1692 дугаартай албан бичиг хүргүүлсэн. Төрийн худалдан авах ажиллагааны газраас худалдан авах ажиллагаа зарлан гүйцэтгэгчээр "Бодь пропертийз" ХХК болон "Төгс гранд констракшн" ХХК-ийн түншлэл 2,400.0 сая төгрөгөөр шалгарч гэрээ байгуулсан.<br>УИХ-ын 2023 оны 39 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний 3.3.2.3. "Хавдар судлалын үндэсний төвийн салбар-II"-ын барилга барих гэж 20,000.00 сая төгрөг тусгагдсан. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд Хавдар судлалын үндэсний төв-2 төсөл арга хэмжээнд 10,000.0 сая төгрөг батлагдсан. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахад шаардлагатай бэлтгэл ажлыг хангаж, Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-д төсөл, арга хэмжээг үүсгээд байна. | | |
| 1.1.8 | ЗГҮАХ 2.1.3.8<br>Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилга барих | Барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн хувь | - | Ажил гүйцэтгэх гэрээ байгуулна. | Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн хоёрдугаар хавсралтын Эрүүл мэндийн сайдын багцын хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад "Эмнэлгийн барилга худалдан авах /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 32 дугаар хороо/" төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нь 40.0 тэрбум | I-IV улирал | 30% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төгрөг, санхүүжих дүн нь 5.[illegible] тэрбум төгрөгөөр батлагдсан бөгөөд Засгийн газрын 2023 оны "Жагсаалт батлах тухай" 409 дүгээр тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2024 оны "Эрх шилжүүлэх тухай" А/12 дугаар тушаалаар Нийслэлийн Засаг даргад эрх шилжүүлсэн. Нийслэлээс худалдан авах ажиллагааг 2024.04.18-ны өдөр зарласан боловч "Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар"-т гомдол гарч, худалдан авах ажиллагаа түр зогссон байсан нь шийдвэрлэгдсэн. Дахин зарласан тендерийн нээлт 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдөр болж оролцогч санал ирүүлээгүй тул амжилтгүй болсон. | | |
| 1.1.9 | Эрүүл мэндийн байгууллагын яаралтай тусламжийн цэг байгуулна. | Яаралтай тусламжийн цэгийн тоо | 2023 оны байдлаар яралтай тусламжийн 10 цэгийг байгуулсан. | Орон нутагт шаардлагатай 40 цэгт яаралтай тусламжийн цэг байгуулагдсан байна. | Эрүүл мэндийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А/120 дугаар тушаалаар 21 аймгийн эрүүл мэндийн газарт яаралтай тусламжийн багцийг хуваарилсан. Эрүүл мэндийн сайдын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/267 дугаар тушаалаар 20 сум, өрхийн эрүүл мэндийн төвд яаралтай тусламжийн тоног төхөөрөмж, түргэний машиныг хуваарилсан. Аймгууд сумын эрүүл мэндийн төвийг түшиглэн яаралтай тусламжийн цэгийг байгуулж, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг ханган ажиллаж байна. Төв аймаг, Хөвсгөл аймгийн Жанхайн даваа, Булган аймгийн Хутаг өндөр, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Хөвсгөл аймаг Мөрөн сум, Өвөрхангай аймаг Өлзийт сум, Дундговь аймаг Баянцагаан сум, Өмнөговь Дэлгэрцогтсум, Сүхбаатар аймгийн Мөнххаан сум, Сэлэнгэ аймгийн Сант сум тус тус сумны эрүүл мэндийн төвийг түшиглэн "Хар цэг" ойролцоох нутаг дэвсгэрт Яаралтай тусламжийн цэгийн байгуулан ажиллаж байна. Дээрх сумын эрүүл мэндийн байгуулагуудад 680 гаруй | I-IV улирал | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | иргэнд тусламж, үйлчилгээ үзүүлсэн. Яаралтай тусламжийн цэгийг байгуулснаар тусламж, үйлчилгээний үзүүлэх хугацаа багассан үр дүн гарсан. | | |
| 1.1.10 | ЗГҮАХ 2.1.4.4<br>Түргэн тусламжийн машины парк шинэчлэл хийнэ. | Шинээр олгосон түргэн тусламжийн автомашины тоо | 50 түргэн тусламжийн автомашин олгосон. | 50 эрүүл мэндийн байгууллагад түргэн тусламжийн автомашин олгосон байна. | 1. Бүгд Найрамдах Польш Улсын “Орон нутагт явуулын эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх тусгай тоноглогдсон автомашин хангаж нийлүүлэх” төслийн хүрээнд 17,5 тэрбум төгрөгийн бүрэн тоноглогдсон 35 түргэн тусламжийн автомашин нийлүүлэгдэж, Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/116, А/212, А/228, А/229, А/264, А/280, А/327 дугаар тушаалаар 6 төв эмнэлэг, 3 дүүрэг, 21 аймгийн эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилсан.<br>2. Дэлхийн банкны “Монгол Улсад Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах” төслийн хүрээнд Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/195, А/400, А/454 дугаар тушаалаар 55 түргэн тусламжийн автомашиныг 13 аймгийн 53 сумын эрүүл мэндийн төвд, АШУҮИС-ийн Монгол-Японы сургалтын эмнэлэгт хуваарилан олгосон.<br>3. Засгийн газрын 2024.02.16-ны 63 дугаар тогтоолын дагуу Засгийн газрын нөөц сангийн хөрөнгөөр өвөлжилт хүндэрсэн орон нутгийн байгууллагуудад эмнэлгийн зориулалттай, туулах чадвар сайтай 60 автомашиныг Эрүүл мэндийн сайдын А/104, А/127 А/188 А/267 дугаар тушаалаар хуваарилсан. (Архангай аймгийн Батцэнгэл, Өндөр-Улаан, Хангай, Чулуут, Хайрхан, Өлзийт, Эрдэнэмандал, Цэнхэр сум, Баян-Өлгий аймгийн Булган, Цэнгэл сум, Булган аймгийн Хишиг-Өндөр сум, Баянхонгор аймгийн Баянговь, | I-IV улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Баянбулаг, Баян-Овоо, Бууцагаан, Баян-Өндөр, Галуут сум, Сэлэнгэ аймгийн Орхон, Номгон, Шаамар сум, Завхан аймгийн Баянтэс, Дөрвөлжин, Их-Уул сум, Өвөрхангай аймгийн Өлзийт, Есөнзүйл, Бүрд, Хайрхандулаан, Сант сум, Төв аймгийн Баяндэлгэр, Баянцогт, Аргалант сум, Хөвсгөл аймгийн Улаан-Уул, Чандмань-Өндөр, Ренчинлхүмбэ Цэцэрлэг сум, Говь-Алтай аймгийн Тайшир, Жаргалан, Халиун сум, Дундговь аймгийн Өлзийт сум, Увс аймгийн Тэс сум, Ховд аймгийн Алтай, Ховд сум, Хэнтий аймгийн Батноров, Баян-Адарга, Биндэр Дархан сум)<br>4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 31 эрүүл мэндийн байгууллагын туулах чадвар сайтай түргэн тусламжийн автомашин худалдан авах 4.2 тэрбум төгрөгийн төсвийг хуваарилан олгосон байна. | | |
| 1.1.11 | ЗГҮАХ 2.1.5.1 Төрөлжсөн мэргэшлийн төв болон аймаг дүүргийн нэгдсэн эмнэлэгт эрүүл мэндийг дэмжих төв байгуулна. | Шинээр байгуулагдсан эрүүл мэндийг дэмжих төвийн тоо | 2023 оны жилийн эцсийн байдлаар 19 аймгийн нэгдсэн эмнэлэг, 4 хөдөөгийн нэгдсэн эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн 5 эмнэлэг, 4 дүүргийн эрүүл мэндийн төв, эрүүл мэндийг | 2 дүүрэг, 2 аймгийн нэгдсэн эмнэлэгт эрүүл мэндийн дэмжих төв байгуулна. | Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1 дэх заалтыг хэрэгжүүлэх, Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилан, зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлүүлж, 21 аймаг, 5 дүүрэгт “Эрүүл мэндийг дэмжих төв” байгуулах төслийн хүрээнд нийт 36,4 тэрбум төгрөгийн барилгын засварын ажил хийгдэж, эмнэлгийн тоног төхөөрөмж (суурин дижитал рентген аппарат, суурин болон зөөврийн эхо, дурангийн оношилгооны иж бүрдэл, тархины цахилгаан бичлэгийн аппарат, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, чих хамар хоолойн болон шүдний оношилгооны иж бүрэн тоног төхөөрөмж, нүдний | I-IV улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | дэмжих төвтэй байна. | | оношилгооны тоног төхөөрөмж, биеийн бүтэц тодорхойлох аппарат, үзлэгийн ор, тэргэнцэр, эмнэлгийн тавилга, ширээ сандал) нийлүүлэгдэж, үйл ажиллагаа эхлүүлсэн. | | |
| 1.1.12 | “Алсын хараа-2050” 2.2.26, ЗГҮАХ 2.1.8.9 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн чанар аюулгүй байдал, бүртгэл, засвар үйлчилгээний тогтолцоог бэхжүүлнэ. | Тогтмол баяжилт хийгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмжийн бүртгэл | 2023 онд эмнэлгийн тоног төхөөрөмжийн бүртгэлийн программд 588 эрүүл мэндийн байгууллагын 1,181 хэрэглэгч, 31,163 эмнэлгийн тоног төхөөрөмж бүртгэгдсэн. | Эмнэлгийн тоног төхөөрөмжийн бүртгэлд тогтмол баяжилт хийсэн байна. | Бүгд Найрамдах Польш Улсын “Орон нутагт явуулын эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх тусгай тоноглогдсон автомашин хангах нийлүүлэх” төслийн хүрээнд эмнэлгийн тоног төхөөрөмжийн хяналт тохируулгын анализатороор тоноглогдсон, эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээнд ашиглах Toyota HiLux болон MAN TGE 3.180 загварын 2 автомашин болон эмнэлгийн тоног төхөөрөмжийн хяналт тохируулгын 5 нэр төрлийн 10 ширхэг анализатор, симуляторын хамт нийлүүлэгдэж, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газарт хуваарилсан. Анализатор, симуляторын угсралт суурилуулалт бүрэн хийгдэж, хүлээлгэн өгсөн. | I-IV улирал | 100% |
| 1.1.13 | ЗГҮАХ 2.1.11.1 Барилга байгууламжийг барьж, тоног төхөөрөмжөөр хангах, хүний нөөцийг бүрдүүлнэ. | Барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн хувь | 2023 онд барилга угсралтын ажил 80 хувийн гүйцэтгэлтэй байна. | Дорнод аймгийн бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн хүүхдийн эмнэлгийн барилгын угсралтын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулсан байна. | Дорнод аймгийн бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн хүүхдийн эмнэлгийн барилгын барилга угсралтын ажлыг дуусгасан бөгөөд Тус ажлын гүйцэтгэл 90 хувьтай бөгөөд 2024 оны 2 дугаар улиралд багтаан ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна. | I-IV улирал | 100% |
| 1.1.14 | ЗГҮАХ 2.1.11.2 Ховд аймгийн БОЭТ-ийн | Батлагдсан ТЭЗҮ, зураг төсөв | Барилгын ажлын зураг төсөл, төсвийн хөрөнгө | Зураг төсөв, ТЭЗҮ-г дуусган, магадлалын | АХБ-ны “Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр” төслийн 1-рүе шатны хүрээнд Олон улсын зөвлөх фирм | I-IV улирал | 80% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | барилгын өргөтгөл барина. | | шийдвэрлэгдсэн. | ерөнхий дуусэлт гаргуулсан байна. | International Medical Center XXK-тэй ажиллаж, БОЭТ-ийн нөхцөл байдлын үнэлгээ, шинэ өргөтгөлийн төлөвлөлт хийгдсэн. Өргөтгөлийн үйл ажиллагааны төлөвлөлтийг баталсан. Ховд БОЭТ-д төлөвлөлт, менежментийн сургалтанд давхардсан тоогоор 136 хүн хамрагдсан. Ховд БОЭТ бүтцээ шинэчлэн батласан ТУЗ байгуулах бэлтгэл шатандаа.<br>Барилгын талбай дахь хуучин барилгыг актлахаар ажиллаж байна. Архитектур төлөвлөлтийн даалгавар гарсан (2/21, АТД-84-18/24). Барилгын загвар зургийг батлуулсан. Барилгын дулаан, цэвэр бохир ус, холбооны техникийн нөхцөл гарсан. Барилгын дэлгэрэнгүй зураг боловсруулах ажил эхэлсэн. | | |
| 1.1.15 | ЗГҮАХ 2.1.12.1 Эрүүл мэндийн салбарын их засварын шилжих 3, шинэ 3 төсөл, арга хэмжээг гүйцэтгэнэ. /2024 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XVIII.2.1- XVIII.2.3/ | Их засварын гүйцэтгэлийн хувь | 2023 оны жилийн эцсийн байдлаар шилжих их засварын ажлын явц 80%-тай байна. | Засврын ажил дуусч хүлээн авсан байна. | -Эх хүүхдийн эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Улаанбаатар, Баянгол дүүрэг/ их засварын хөрөнгө батлагдаж, олон улсын жишигт нийцсэн төрөх тасагтай болох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр эхлүүлсэн. Үүнд:<br>Багц-1 "ЭХЭМҮТ-ийн төрөх тасгийн засвар"-ын ажлын гүйцэтгэгчээр "Эл Эс Би" XXK шалгарч 1,219.4 тэрбум төгрөгийн гэрээ байгуулан 2022 онд Улсын комисст хүлээлгэн өгсөн.<br>Багц-2 "ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн эмнэлгийн /блок 6-4/ дотор засвар"-ын ажилын гүйцэтгэгчээр "Скудо Тауэр" XXK шалгарч 1,865.9 тэрбум төгрөгийн гэрээ байгуулан 2023 онд Улсын комисст хүлээлгэн өгсөн.<br>Багц-3 "ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн эмнэлгийн /блок 6-4/ халаалт, агаар сэлгэлт, цэвэр бохир усны шугам сүлжээ, дотор гэрэлтүүлэг, холбоо дохиоллын шугам сүлжээний засвар"-ын ажлын гүйцэтгэгчээр | I-IV улирал | 80% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | "Алтайнбумбам өргөө" ХХК шалгарч 2,185.1 тэрбум төгрөгийн гэрээ байгуулан 2023 онд Улсын комисст хүлээлгэн өгсөн.<br>Багц-4 "ЭХЭМҮТ-ийн дулаан дамжуулах төв болон гол дамжуулах шугам хоолойн засвар"-ын ажлын гүйцэтгэгчээр "Нэкстстандарт" ХХК шалгарч 2,576.2 тэрбум төгрөгийн гэрээ байгуулан 2023 онд Улсын комисст хүлээлгэн өгсөн.<br>Багц-5 "ЭХЭМҮТ-ийн Хавдрын эрт илрүүлгийн төвийн барилгын гадна шугам сүлжээний засвар"-ын ажлын гүйцэтгэгчээр "Байгаль Алтай" ХХК шалгарч 151.5 сая төгрөгийн гэрээ байгуулан 2022 онд Улсын комисст хүлээлгэн өгсөн.<br>Багц-6 "ЭХЭМҮТ-ийн Цахилгаан шатны шинэчлэл, засварын ажил"-ын ажлын гүйцэтгэгчээр "Төвхөн Трейд" ХХК шалгарч 3,126.3 тэрбум төгрөгийн гэрээ байгуулан 2024 онд улсын комисст хүлээлгэн өгсөн.<br>Багц-7 "ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн эмнэлгийн /блок 6-2, яаралтай тусламж, Гемодиализын тасаг, Хоол боловсруулах эрхтэний эмгэг судлалын тасгийн засвар", мөн "Хүчилтөрөгчийн хийн хангамжийн нэмэлт ажил"-ын засварын гэрээг "Ононбридж" ХХК-тай 2,475.6 тэрбум төгрөгийн дүнтэй байгуулан 2024 онд улсын комисст хүлээлгэн өгсөн.<br>- Багц-8 "ЭХЭМҮТ-ийн Эх барих эмэгтэйчүүдийн байрны засвар"-ын ажлын гүйцэтгэгчээр "Алтайнбумбат" ХХК-тай 14,599.9 тэрбум төгрөгийн дүнтэй гэрээг байгуулан 2024 оны 12 сарын 10-ны өдрийн байдлаар 80 хувийн гүйцэтгэлтэй байна.<br>- Нэгдсэн эмнэлгийн барилга, дотор сантехникийн засвар /Сэлэнгэ, Сүхбаатар сум/ төсөл арга хэмжээг | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Эрүүл мэндийн сайдын 202[illegible] оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн А/12 дугаар тоот тушаалаар Сэлэнгэ аймгийн Засаг даргад эрх шилжсэн. Аймгаас худалдан ажиллагаа 5 удаа зарласан боловч 4 удаа амжилтгүй боловч 2024 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр “Бүрэн-Одод” ХХК-д гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлсэн.<br>- Эрүүл мэндийн их засвар /Улсын хэмжээнд/- Улсын хоёрдугаар төв эмнэлэг барилгын их засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/, төсвийн тухай хууль, аудитын зөвлөмжийн дагуу нэмэлт ажлын гэрээг “Дэвжих уран өргөө” ХХК-тай байгуулан энэ онд санхүүжих санхүүжилтийг бүрэн олгосон. Ажил нь дуусч хүлээлгэн өгсөн.<br>- Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Е блокийн цэвэр бохир усны шугам сүлжээ болон эрчимт эмчилгээ, дурангийн өрөөний салхивчны их засвар /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ төсөл арга хэмжээний ХАА-г зарласан. | | |
| | | | | | | - Улсын нэгдүгээр төв эмнэлгийн барилгын гадна их засвар /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаа зарлан “Би Рич Трейд” ХХК-тэй 3,284.5 сая төгрөгийн гэрээ байгуулан ажлыг нь эхлүүлсэн.<br>- Эрүүл мэндийн салбарын их засвар /Улсын хэмжээнд/ төсөл арга хэмжээ нь Төсвийн тухай хуулиар 3,554.5 сая төгрөг батлагдсан. Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/146, А/245 дугаар тоот тушаалуудаар жагсаалтыг 7 төсөл арга хэмжээгээр баталж, tender.gov.mn цахим системд ажлыг үүсгэн эрүүл | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мэндийн байгууллагуудад эрх шилжүүлээд байна. Эрх шилжүүлсэн байгууллагуудаас худалдан авах ажиллагаа зарлан гүйцэтгэгч нартай гэрээ байгуулсан бөгөөд ажлын гүйцэтгэл 80 хувьтай байна. | | |
| 1.1.16 | ЗГҮАХ 2.1.12.3 Эрүүл мэндийн салбарын шилжих 41 төсөл, арга хэмжээний батлагдсан төсвийн хүрээнд барилга угсралтын ажлыг үргэлжлүүлнэ. /2024 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XVIII.1.1- XVIII.1.44/ | Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь | Барилга угсралтын ажлын 11 төсөл, арга хэмжээ 90%-аас дээш, 21 төсөл арга хэмжээ 70-89%-тай, 14 төсөл, арга хэмжээ 40-69%-тай, 6 төсөл, арга хэмжээ 20-39%-тай байна. | Батлагдсан төсвийн хүрээнд санхүүжүүлж, барилга угсралтын ажлынг бүрэн дуусгасан байна. | Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд барилга байгууламжийн 78 төсөл, арга хэмжээ батлагдсанаас 23 барилга байгууламж ашиглалтад ороод байна. Үлдсэн 55 барилга байгууламжаас<br>➢ 80-99 хувийн гүйцэтгэлтэй 11<br>➢ 50-79 хувийн гүйцэтгэлтэй 9<br>➢ 30-49 хувийн гүйцэтгэлтэй 3<br>➢ 0-29 хувийн гүйцэтгэлтэй 22<br>Худалдан авах ажиллагааны шатанд 10 байна. | I-IV улирал | 100% |
| 1.1.17 | Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн нөхөн үржихүй болон хүүхдийн зөвлөх поликлиникийн барилга угсралтын ажлыг дуусгаж ашиглалтад оруулна. | Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь | 2023 оны жилийн эцсийн байдлаар барилгын ажлын явц 75 хувьтай байна. | Барилга угсралтын ажлыг дуусгаж, Улсын комисст хүлээлгэн өгсөн байна. | ➢ "Хүүхдийн зөвлөх поликлиник"-ийн барилгын өргөтгөл /Улаанбаатар, Баянгол дүүрэг/ ажлын гүйцэтгэл 85 %-тай бөгөөд дотор заслын ажил, шалны плитаны ажил гүйцэтгэж байна.<br>➢ "Нөхөн үржихүйн зөвлөх поликлиник"-ийн өргөтгөлийн барилга /Улаанбаатар, Баянгол дүүрэг/ төсөл, арга хэмжээний "Барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах комиссын акт" 2024 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн БА-118/2024 дугаартай баталгаажиж, ашиглалтад орсон. | I-IV улирал | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1.18 | ЗГҮАХ 2.1.12.3 Эрүүл мэндийн салбарын шилжих 43 тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээг батлагдсан төсвийн хүрээнд санхүүжитийг олгоно. /2024 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XVIII.3.1- XVIII.3.43/ | Тоног төхөөрөмжийн хангалтын гүйцэтгэлийн хувь | 2023 оны эрүүл мэндийн салбарын шилжих 14 тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл бүрэн хэрэгжсэн. | Тоног төхөөрөмжийн хангалт 100%-ийн гүйцэтгэлтэй байна. | 1. Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж байгаа 10 хөрөнгө оруулалтын 2.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон.<br>2. 2024 онд хэрэгжиж буй 42 төсөл арга хэмжээний нийлүүлэгчийг шалгаруулах тендер Төрийн худалдан авах ажиллагааны газарт 10 төсөл арга хэмжээ, аймаг нийслэлийн засаг даргын тамгын газарт эрх шилжүүлсэн-23, эрүүл мэндийн яаманд -8 төсөл арга хэмжээний тендер зохион байгуулагдан, гэрээг баталгаажуулсан. | I-IV улирал | 100% |
| 1.1.19 | ЗГҮАХ 2.1.14.1, МУТЖҮЧ-2.2 Эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудыг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгоно. | Шинээр орчин үеийн нүхэн жорлон, ариун цэврийн байгууламжтай болсон сумын эрүүл мэндийн тоо | 33 сумын эрүүл мэндийн төв сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болсон. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд сумын эрүүл мэндийн төвийн барилга 38 батлагдсан | 60 сумын эрүүл мэндийн төвийг үе шаттайгаар орчин үеийн нүхэн жорлон, ариун цэврийн байгууламжтай болгосон байна. | Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд сумын эрүүл мэндийн төвийн барилга, өргөтгөлийн барилга 38 батлагдсанаас 14 сумын эрүүл мэндийн төвийн барилга, өргөтгөлийн барилга ашиглалтад ороод байна. Үлдсэн 24 сумын эрүүл мэндийн төвийн барилга, өргөтгөлийн барилгаас<br>➢ Худалдан авах ажиллагааны шатанд 4<br>➢ 80-99 хувийн гүйцэтгэлтэй 5<br>➢ 50-79 хувийн гүйцэтгэлтэй 4<br>➢ 30-49 хувийн гүйцэтгэлтэй 2<br>0-29 хувийн гүйцэтгэлтэй 9 | I-IV улирал | 80% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1.1.20 | Түргэн тусламжийн тээврийн хэрэгслийн стандартыг шинэчилнэ. | Батлагдсан стандарт | 2018 онд батлагдсан Түргэн тусламжийн төвийн бүтэц, үйл ажиллагаа стандартаар зохицуулагдаж байна. | Сумын эрүүл мэндийн төв болон лавлагаа шатлалд ашиглах түргэн тусламжийн тээврийн хэрэгслийн стандартыг боловсруулж батлуулсан байна. | Түргэн тусламжийн төвийн бүтэц, үйл ажилллагаа, MNS 6717:2018 стандартын В хавсралтаар батлагдсан "Түргэн тусламжийн автомашинд тавих нийтлэг шаардлага"-ыг шинэчлэн сумын эрүүл мэндийн төв болон лавлагаа шатлалд ашиглах түргэн тусламжийн тээврийн хэрэгслийн стандартыг төслийг боловсруулж байна. | I-IV улирал | 30% |
| 1.1.21 | Эрүүл мэндийн яамны цахилгааны нөөцийн шугамыг бий болгоно. | Нөөц шугамын тоо | | Цахилгааны нөөц шугамыг шинээр бий болгосон байна. | ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 2/1339 албан бичгээр "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-д техникийн нөхцөл авахаар хүсэлт хүргүүлсэн боловч олгох боломжгүй гэсэн шийдвэр гарсан. Дахин эх үүсвэр судлуулахаар 2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 7/3969 дугаартай "Техникийн нөхцөл хүсэх тухай" албан бичиг "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-д хүргүүлээд байна. Техникийн нөхцөл авсны дараагаар зураг хийгдэнэ. | I-IV улирал | 50% |
| 1.2 Эрүүл мэндийн салбарын эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын хэрэгцээг судалж, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийг боловсруулах, зохицуулах, нягтлан бодох бүртгэл хөтлөх, тайлагнах; | | | | | | | |
| 1.2.1 | Тусгай сангийн тухай хуулийн дагуу Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах тайлагнах | Төсөл арга хэмжээний тоо, зарцуулсан мөнгөн дүн | 2,058.0 сая төгрөг | Тусгай сангийн тухай хууль, эрүүл мэндийн дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах журмын дагуу зарцуулж, тайлагнасан байна. | Тайлант онд 9,810.0 сая төгрөгийн төсөв батлагдаж, ЭМС-ын 2023 оны 01,04,05 дугаар тушаалаар хэрэгжсэн 14 төслийн үлдэгдэл санхүүжилт болох 30 хувийн санхүүжилтээс 2.2 сая төгрөгийн алданги тооцоолж, суутган 107.1 сая төгрөгийг, ЭМС-ын 2024 оны А/417 тушаалаар гадаад сургалтын урьдчилгаа санхүүжилт 500,0 сая төгрөгийг ЭМХТ-д, ЭМС-ын 2024 оны А/430 тушаалаар гадаад эмчилгээний хөнгөлөлт 28 иргэнд 1,524.4 сая төгрөгийг, амьгүй донорын оршуулгын зардалд 3.5 сая | I-IV улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төгрөгийг олгосноор 2,135.0 сая төгрөгийг зарцуулаад байна. | | |
| 1.2.2 | Эрүүл мэндийн байгууллагуудын сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээнд үнэлгээ хийж, хагас жил тутамд зөвлөмж, чиглэлийг хүргүүлж, төсвийн сахилга батыг сайжруулах | Албан бичгийн огноо дугаар, зөвлөмжийн тоо | 2 удаа зөвлөмж, чиглэл хүргүүлсэн. | Хагас, бүтэн жилээр зөвлөмж, чиглэл хүргүүлсэн байна | - Эрүүл мэндийн сайдын багцын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд дүн шинжилгээ хийж, Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулга хийлээ. Мөн санхүүгийн тайлангийн аудитаар дүгнэлт өгөхөөс татгалзсан-4, сөрөг дүгнэлт авсан-3 байгууллагын удирдлага санхүүгийн ажилтанд хариуцлага тооцох Эрүүл мэндийн сайдын 2024 оны 8 дугаар сарын 1-ний өдрийн 1а/3135, 1а/3136, 1а/3137, 1а/3138, 1а/3139 албан бичгийг 5 аймгийн Засаг даргад хүргүүлж, хариуг албан бичгээр хүлээн авлаа. Эхний хагас жилийн санхүүгийн тайланг байгууллага нэг бүрээр урьдчилан хянан, цахимаар заавар зөвлөгөө, өгч алдааг засуулан тайлагнуулан нэгтгэлээ.<br><br>- Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүждэг эрүүл мэндийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийн мэдээнд сар бүр эх үүсвэр дутагдаж буй эсэх, өр төлбөр үүссэн эсэх, авлага барагдсан эсэхэд дүн шинжилгээ хийж нэгжийн удирдлагад тухай бүр танилцуулан ажилласан. Мөн Аймаг нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудад 2024 оны 1а/267, 1а/1721, 1а/2514, 2/3707, 2/3708, 2/3709, 2/3710, 7/5763, 2/1405, 2/4286, 2/2840, 2/2606, 2/1964, 7/1616 албан бичгээр болон цахимаар хөтөлбөр зориулалтын дагуу төсвийг захиран зарцуулж, төсвийн сахилга баттай ажиллах, мөн 2025 оны төсвийн төслийн саналыг үндэслэл тооцоолoлтой төлөвлөж ирүүлэх талаар зөвлөмж чиглэл өгч ажилласан. Мөн | I-IV улирал | 97% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | санхүүжилт хүндэрсэн сум, тосгон болон дүүргийн эрүүл мэндийн байгууллагуудын удирдлагуудтай Сайдтай хийсэн уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулахад төсөв, санхүүтэй холбоотой мэдээллийг удирдлагын багт гаргаж өгч ажиллалаа. | | |
| 1.2.3 | Эрүүл мэндийн байгууллагуудын төсвийн зарлагын төлөвлөлтийг орлоготой уялдуулан төлөвлөх, төсвийн нэгдсэн программд оруулах | Сангийн яамны FISCAL программ ашиглаж байгаа байгууллага | Сангийн яамны FISCAL программ нэвтэрсэн | Эрүүл мэндийн байгууллагуудын төсвийн зарлагын төлөвлөлтийг орлоготой уялдуулан төлөвлөх, төсвийн нэгдсэн программд оруулсан байна. | Эрүүл мэндийн сайдын багцын лавлагаа 66 байгууллага, анхан шатны 332 байгууллагын төсвийн сар, улирлын хуваарийн өөрчлөлт, зохицуулалтыг FISCAL программаар хүлээн авч хянан, нэгтгэлийг Сангийн 2024.01.03 1а/11, 2024.01.24 1а/332, 2024.01.30 1а/411, 2024.02.29 1а/872, 2024.03.15 1а/1090, 2024.04.01 1а/1289, 2024.04.19 1а/1610, 2024.04.30 1а/1809, 2024.05.27 1а/2245, 2024:05.30 1а/2315, 2024.07.24 1а/3033, 2024.08.02 1а/3169, 2024.08.23 1а/3450, 2024.09.04 1а/3618, 2024.10.14 1а/4183, 2024.11.05 1а/4524, 2024.11.20 1а/4854, 2024.11.25 1а/4948 дугаар албан бичгээр нийт 18 удаа хүргүүлэн шийдвэрлүүлсэн. Мөн Сангийн яамнаас хянагдаж, шинэчлэгдсэн баазыг хүлээн авч аймаг нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудад тухай бүр хүргүүлж ажилласан. | I-IV улирал | 90% |
| 1.2.4 | Эрүүл мэндийн салбарын албан хаагчдын цалингийн доод жишгийг нэмэгдүүлэх тооцооллыг хийж, санал боловсруулан хүргүүлж, шаардагдах | Хүргүүлсэн албан тоот, дотоод бичиг, тооцоолол | Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоол | Эрүүл мэндийн салбарын албан хаагчдын цалингийн доод жишгийг ЗГ-ийн тогтоолоор батлуулж хэрэгжүүлнэ | Эрүүл мэндийн салбарын албан хаагчдын цалингийн доод жишиг батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөлд 1 удаа санал боловсруулан удирдлагад танилцуулж, Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлэн журмын төсөлд тусгуулж, Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор батлагдсан байна. Тогтоол гарсантай холбоотойгоор улсын төсвөөс санхүүждэг 49 байгууллагын 5195 мянган албан хаагчийн цалингийн зардалд 4,4 тэрбум төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүждэг байгууллагын | I-IV улирал | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | төсвийг нэмж батлуулах | | | - | 28604 мянган албан хаагчийн цалингийн зардалд 152,5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх тооцоо судалгаа хийж 2024 оны 04-12 сарын хуваарьт нэмэлт өөрчлөлтийг оруулж, Сангийн яаманд 2024 оны 1а/1289 дүгээр албан бичгээр хүргүүлж шийдвэрлүүлэн ТАЦНС программаар 446 байгууллагын 32,8 мянган эмч, эмнэлгийн ажилтанд 1,1 их наяд төгрөгийн цалин хөлс олгож хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. | | |
| 1.2.5 | Эрүүл мэндийн салбарын аймаг, сум, алслагдсан 3 дүүрэгт ажиллаж буй эмч, эмнэлгийн ажилчдад олгох орон нутгийн нэмэгдлийг ангилал зэрэглэл харгалзахгүй олгох тооцооллыг хийж санал боловсруулан хүргүүлж, шаардагдах төсвийг нэмж батлуулах | Хүргүүлсэн албан тоот, дотоод бичиг, тооцоолол | Засгийн газрын 2018 оны 382, 2023 оны 242 дугаар тогтоол | Эрүүл мэндийн салбарын аймаг, сум, алслагдсан 3 дүүрэгт ажиллаж буй эмч, эмнэлгийн ажилчдад олгох орон нутгийн нэмэгдлийг ангилал зэрэглэл харгалзахгүй олгох шийдвэрийг ЗГ-ийн тогтоолоор батлуулж хэрэгжүүлнэ | Эрүүл мэндийн салбарын аймаг, сум, алслагдсан 3 дүүрэгт ажиллаж буй эмнэлгийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийг ангилал, зэрэглэл харгалзахгүй олгох тухай Засгийн газрын тогтоолын төсөлд 1 удаа санал боловсруулан удирдлагад танилцуулж, Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлэн журмын төсөлд тусгуулж, Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоолоор батлагдсан. Тогтоол гарсантай холбоотойгоор 18343 албан хаагчийн цалингийн зардалд 71,7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх тооцоо судалгаа хийж, 2024 оны 04-12 сарын хуваарьт нэмэлт өөрчлөлтийг оруулж, Сангийн яаманд 2024 оны 1а/1289 дүгээр албан бичгээр хүргүүлж шийдвэрлүүлэн ТАЦНС программаар 332 сум тосгоны 7959 эмч, эмнэлгийн ажилтан, 21 ЭМГ, ЭМБ болон алслагдсан 3 дүүргийн 11078 эмч, эмнэлгийн ажилтанд бүрэн олгуулан ажиллаж байна. | I-IV улирал | 100% |
| 1.2.6 | Эрүүл мэндийн сайдын багцын 2023 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн | Тайлан өгсөн эрүүл мэндийн байгууллагын тоо | Жил бүр холбогдох хууль, НББОУС-ын дагуу гаргасан санхүүгийн | Эрүүл мэндийн сайдын багцын 2023 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, | Эрүүл мэндийн сайдын багцын 2023 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу 451 байгууллагын тайланг хамруулан нэгтгэн, Төрийн аудитын байгууллагаар аудит хийлгэн СЯ-д хуулийн | I-II улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу тайлагнана. | Зөрчилгүй санал дүгнэлт авсан байгууллагын тоо | нэгтгэсэн тайлан | Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу тайлагнаж СЯ-д хүргүүлсэн байна. | хугацаанд хүргэж нэгтгүүллээ. Санхүүгийн тайлангийн аудитаар 370 байгууллагад дүгнэлт гарснаас 311 байгууллага өөрчлөлтгүй, 51 байгууллага хязгаарлалттай, 3 байгууллага, сөрөг дүгнэлт авч, 4 байгууллагад дүгнэлт өгөхөөс татгалзсан байна. Мөн 79 байгууллага түүвэрт хамрагдсан. 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд 451 байгууллагын тайланг нэгтгэн хуулийн хугацаанд нь Сангийн яаманд хүргэн нэгтгүүллээ. | | |
| 1.2.7 | Эрүүл мэндийн сайдын багц, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаар, 2026-2027 оны дунд хугацааны төсвийн төсөөллийг боловсруулж, Сангийн яаманд хүргүүлнэ. | Батлагдсан хууль | Эрүүл мэндийн сайдын багц, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны батлагдсан төсөв | Эрүүл мэндийн сайдын багц, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаар, 2026-2027 оны дунд хугацааны төсвийн төсөөллийг боловсруулж, Сангийн яаманд хүргүүлнэ. | Эрүүл мэндийн сайдын багц, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдөр 1а/1083 дугаар албан бичгээр 19 арга хэмжээнд 1,141,4 тэрбум төгрөг, төсвийн хязгаарын саналыг 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 1а/2514 дүгээр албан бичгээр 29 арга хэмжээнд 1,291.8 тэрбум төгрөгийн саналыг нэгтгэн боловсруулж Сангийн яаманд тус тус хүргүүлсэн. | II улирал | 100% |
| 1.2.8 | Эрүүл мэндийн сайдын багц, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсвийн төсөөллийг боловсруулж, Сангийн яаманд санал хүргүүлж, батлуулна. | Батлагдсан хууль | Эрүүл мэндийн сайдын багц, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны батлагдсан төсөв | Эрүүл мэндийн сайдын багц, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсвийн төсөөллийг боловсруулж, хуулийн хугацаанд нь | 2025 оны төсвийн төсөл, 2026, 2027 оны төсвийн төсөөллийн саналыг эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлийг сайжруулах, Эрүүл мэндийн даатгалын сангийн тогтвортой байдлыг хангах зорилгоор эрүүл мэндийн багц хуулиуд, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Сангийн сайдын 2024 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн “Төсвийн удирдамж хүргүүлэх тухай” 01/5374 дугаар албан бичиг болон бусад холбогдох хууль, эрх зүйн баримт бичгийн дагуу боловсруулж, | III-IV улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Сангийн яаманд санал хүргүүлж, батлуулсан байна. | 2024 оны 07 дугаар сарын 23-ны өдөр удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хянуулж, Монгол Улсын Их Хурал, Сангийн яам, Үндэсний аудитын газарт 1а/3042 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Мөн 2025 оны төсвийн төслийг олон нийтэд ил тодоор мэдээлж цахим хэлбэрээр санал асуулга авч Сангийн яаманд 2024.08.19 2/3401 дүгээр албан бичгээр хэлэлцүүлгийн үр дүнг нэгтгэн хүргүүлсэн ба 2024.09.26-ны өдөр Засгийн газрын ордонд нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүд, Сангийн яам болон олон нийтийн төлөөллийг байлцуулан нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулсан. | | |
| 1.2.9 | Эрүүл мэндийн сайдын багцын дүнгээр тайлагнадаг төсөв, санхүүгийн мэдээллийг Шилэн дансны тухай хуулийн дагуу хугацаанд нь тайлагнах, мэдээллэх | Журмын дагуу байршсан мэдээллийн тоо | 2023 оны хэрэгжилт | Шилэн дансны цахим хуудаст мэдээлсэн байна | Шилэн дансны системд төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн данс төсөв гүйцэтгэлийн 72 мэдээ байршуулахаас 70 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроон, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой 24 мэдээллээс 22 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроон, бусад 45 мэдээлэл байршуулахаас 74 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.<br>Эрүүл мэндийг дэмжих сангийн төсөв гүйцэтгэлийн 61 мэдээ байршуулахаас 57 мэдээллийг хугацаанд нь, 4 мэдээллийг хугацаа хоцроон, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой 24 мэдээллийг хугацаанд нь бүрэн, бусад 67 мэдээлэл байршуулахаас 66 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна. | I-IV улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2.10 | Эрүүл мэндийн байгууллагуудын төлбөр тооцооны гүйлгээ, хяналт, баримтын бүрдүүлбэр, төрийн сангийн үйл ажиллагааны хэрэгжилтийг хэвийн явуулах | Төлбөр тооцооны тоо | 2023 оны хэрэгжилт | Эрүүл мэндийн байгууллагуудын санхүүгийн хэвийн үйл ажиллагаа хангагдсан байна. | 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 12 дугаар сарын 5-ны өдрийн байдлаар Эрүүл мэндийн яам болон харьяа 21 байгууллага, ЭМДаатгалын сан, ЭМДэмжих сангийн нийт 45 данс хооронд давхардсан тоогоор 4,6 их наяд төгрөгийн 77,765 ширхэг зарлагын гүйлгээг Төрийн сангийн үйл ажиллагааны журам болон бусад хууль, дүрмийн дагуу холбогдох анхан шатны баримт, батлагдсан төсвийн хуваарь, эдийн засгийн ангиллын дагуу хянаж, бүрдэл болсон зарлагын гүйлгээг цахим системээр хянан баталгаажууллаа. | I-IV улирал | 100% |
| 1.2.11 | Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төвийн статусыг тодорхой болгож ЭМЯ-ны хөрөнгөд бүртгэлтэй байгаа барилгыг ашиглагч байгууллагад шилжүүлж өгөх | Судалгааны тоо | Судалгаа хийгдсэн. | Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төвийн статусыг тодорхой болгож ЭМЯ-ны хөрөнгөд бүртгэлтэй байгаа барилгыг ашиглагч байгууллагад шилжүүлэх талаар асуудлыг холбогдох байгууллагад уламжилсан байна. | Эрүүл мэндийн яамны ТНБД-ын 2024 оны А/43 тушаалаар МСДАУТ-д ажлын хэсэг байгуулагдаж, 2024.04.22-ны өдөр ажлын хэсэг ажилласан.<br>Ажлын хэсгийн хүрээнд өнөөгийн нөхцөл байдал, өмч хөрөнгийн талаар болон хүний нөөц, санхүүжилтийн талаархи мэдээллийг авч, хянасан.<br>Үр дүнд МСДАУТ нь 2004 оноос үйл ажиллагаа явуулж, өөрийн санхүүжилтээр бие дан ажилласан бөгөөд Оргил рашаан сувилалд сүүлийн 10 жилийн байдлаар газрын төлбөрт 181.5 сая төгрөгийг тушаасан байна.<br>Гэвч МУЗГ болон БНСУ-ын буцалтгүй тусламжаар Оргил рашаан сувилалыг түшиглэн байгуулсан уг төв Оргил рашаан сувилаллыг хувьчилсантай холбоотойгоор өмчийн маргаан үүсэж эхэлсэн байна.<br>Иймд ажлын хэсэг тайландаа холбогдох дүгнэлтийг хавсаргаж цаашид авч хэрэгжүүлэх 4 саналтайгаар ТНБД-д тайланг танилцуулсан.<br>Үүнд: | I-IV улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - Тус төвийн статус, харьяуцлагын хэлбэр, харьяалал, удирдлага эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох.<br>- ЭМЯ харьяа тул Төрийн албаны тухай хуулийн 54.2, 55.1-т заасны дагуу төрийн байгууллагын болон албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөө, үр дүнг холбогдох журмын дагуу байгуулж, үнэлж дүгнэх.<br>- Тус төвөөс эмчилгээнд ашиглагдаж буй эмэнд холбогдох хууль, дүрэм журмын дагуу чанар аюулгүй байдлыг хангуулах.<br>- БНСУ болон МУЗГ-аас хамтран ажиллах хүрээнд МУЗГ-ын үүрэгт газрыг шийдвэрлэж, Оргил рашаан сувилалын 10 өрөөг олгосон байдаг. Иймд хэрэгжилтийг хангуулж, ТӨБЗГ-т уламжилж, асуудлыг шийдвэрлүүлэх. | | |
| 1.2.12 | Гүйцэтгэлийн санхүүжилтийг зарцуулах хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих" журмын төслийн боловсруулан батлуулах, хэрэгжилтийг хангах | Батлагдсан журмын огноо, дугаар | Журмын төсөл боловсруулагдсан. | Журам батлагдсан байна. | Гүйцэтгэлийн санхүүжилтийг зарцуулах хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих" журмын төслийг 12 бүлэгтэйгээр боловсруулсан бөгөөд төсвийн төслийг боловсруулах, төлөвлөх, батлуулах, төсөвт өөрчлөлт оруулах, нэмэлт эх үүсвэргийг зарцуулах, төрийн сангийн үйл ажиллагаа болон зардлыг хянах, санхүүгийн тайлан нэгтгэх, хариуцлага ба урамшуулал гэсэн бүлгийн хүрээнд боловсруулж, хэлтсийн хүрээнд танилцуулагдаж удирдлагаас журмын төслийг дахин сайжруулан боловсруулах чиглэл өгсний дагуу дахин сайжруулалт хийдэж байна. | I-IV улирал | 33% |
| 1.2.13 | Эрүүл мэндийн сайдын багцын Улсын төсвөөс хариуцах | Хөтөлбөр, зориулалтын тоо, | 1.024,7 тэрбум төгрөг | Хөтөлбөр, зориулалтын дагуу санхүүжилтийг | Тайлант онд 1,179.9 тэрбум төгрөгийн төсөв батлагдан эхний 12 дугаар сарын 5-ны байдлаар 1,081.8 тэрбум төгрөгийг зарцууллаа. Үүнд Нийгмийн эрүүл мэндийн | I-IV улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | эмнэлгийн тусламж үйлчилгээний санхүүжилтийг холбогдох тушаал, шийдвэр, гэрээнд үндэслэн санхүүжүүлэх, тайлагнах | зарцуулсан мөнгөн дүн | | бүрэн олгосон байна. | хөтөлбөр /71601/-ийн хүрээнд ХӨСҮТ-д 11,3 тэрбум төгрөгийн, СЭМҮТ-д 4,3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож, ЭМС-ын А/345 тушаалаар Элэг бүтэн монгол арга хэмжээнд 4,2 тэрбум төгрөгөөр Д вирусын эм худалдан авах, Эрүүл шүд арга хэмжээнд 12.0 сая төгрөг, А/150 тушаалаар нүүдлийн эмнэлгийн эрт илрүүлэх үзлэгт 868.6 сая төгрөг, А/177, А/198 тушаалаар Төрийн бүтээмж-Цахим сургалт арга хэмжээнд 769,3 сая төгрөг, Эрүүл монгол хүн арга хэмжээнд 880.3 сая төгрөг, А/268, А/241 тушаалаар 28 эрүүл мэндийн байгууллагад нэн шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авахад 1.0 тэрбум төгрөгийг олголоо.<br>Эмнэлгийн тусламж үйлчилгээний хөтөлбөр /71602/-ийн хүрээнд ЭМС-ын А/395 тушаалаар УХТЭ-т 2,7 тэрбум төгрөгийн, ЭМДЕГ-т төр даах болон улсын төсвөөс олгох тусламж үйлчилгээний санхүүжилтэд 1,030.7 тэрбум төгрөгийн, НҮБ болон дотоодоос худалдан авах вакцины зардалд 17.5 тэрбум төгрөгийг, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулалд 2.5 тэрбум төгрөгийг шилжүүллээ. Мөн А/152, А/145, А/210, А/202, А/252, А/269, А/255, А/325 тушаалаар эрүүл мэндийн байгууллагад нэн шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авахад 2.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олголоо.<br>Эрүүл мэндийн бодлого, удирдлага хөтөлбөр /71603/-ийн хүрээнд цахим бодлогын арга хэмжээнд ЭМС-ын А209, А/231 тушаалаар эрүүл мэндийн байгууллагуудад компьютер, техник хэрэгсэл худалдан авахад 1.2 тэрбум төгрөг зарцуулаад байна. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2.14 | Эрүүл мэндийн салбарт хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг холбогдох гэрээнд үндэслэн гүйцэтгэлийн дагуу санхүүжүүлэх, тайлагнах | Хөтөлбөр, зориулалтын тоо, зарцуулсан мөнгөн дүн | 137.8 тэрбум төгрөг | Хөтөлбөр, зориулалтын дагуу санхүүжилтийг бүрэн олгосон байна. | Тайлант онд 282.6 тэрбум төгрөгийн төсөв батлагдаж 12 дугаар сарын 5-ны байдлаар 49 барилгын гүйцэтгэлд 63.4 тэрбум төгрөгийн, 14 их засварын ажилд 14.9 тэрбум төгрөгийн, эрүүл мэндийн байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэх машин, тоног төхөөрөмж худалдан авахад 20 гүйцэтгэгчид 11.1 тэрбум төгрөгийг нийт 89.6 тэрбум төгрөгийг олгоод байна. | I-IV улирал | 100% |
| 1.2.15 | ЗГҮАХ 2.1.7 Төр хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад Улсн төсөв (ЭМДС)-гаас амбулатори, өдрийн эмчилгээ, оношилгоонд олгох санхүүжилтийн ялгааг арилгана. | Гэрээ байгуулсан хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын эзлэх хувь | ЭМДҮЗ-ийн 2023 оны 08 дугаар тогтоолоор суурь тарифыг баталсан. | Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын 90 хувьд гэрээ байгуулж, олгосон байна. | Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ худалдан авах сонгон шалгаруулалтад тэнцсэн 196 хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагатай 3 жил буюу 2022-2025 оны хугацаатай даатгалын гэрээг 2022 оны 09 дүгээр сард байгуулсан. Улсын хэмжээнд 215 ортой хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас үүний 193 нь гэрээ байгуулсан нь 89.8% эзэлж байна. Улсын хэмжээнд 1,458 оргүй хувийн эмнэлэг клиник хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байгаа үүний зөвхөн 5 эмнэлэгтэй гэрээ байгуулж, энэ нь 0.34 хувийг эзэлж байна. Клиник хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байгаа 1,458 хувийн эмнэлэг байгаа бөгөөд цаашид магадлан итгэмжлэлд хамрагдаж, эрүүл мэндийн даатгалын гэрээ байгуулах эрх үүсэх юм. Улсын хэмжээнд хувийн хэвшлийн 1,673 оргүй болон ортой хувийн хэвшлийн эмнэлэг үйл ажиллагаа явуулж байгаагаас 196 нь эрүүл мэндийн даатгалын гэрээ байгуулсан нь 11.7 хувийг эзэлж байна.<br>2024 оны эхний 11 сарын байдлаар 244.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Эрүүл | I-IV улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мэндийн даатгалын сангаас гэрээт хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад олгосон байна. | | |
| Бусад газартай хамтран хэрэгжүүлэх арга хэмжээнууд | | | | | | | |
| 1.2.16 | ЗГҮАХ 1.1.2.4<br><br>Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийг улирлын томуугийн вакцинд бүрэн хамруулна. | Худалдан авсан вакцины тоо хэмжээ, мөнгөн дүн | 4,800.7 сая төгрөг | Гэрээний дагуу шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэсэн байна. | 2024 оны вакцин, биобэлдмэл, зүү тариурын НҮБ-ын хүүхдийн сангаар дамжуулан худалдан авахад 21.4 тэрбум төгрөг, дотоодын ханган нийлүүлэгчээр дамжуулан худалдан авахад 1.9 тэрбум төгрөгийг баталсан байна. Үүнээс томуугийн эсрэг вакцин худалдан авахад 7.5 тэрбум төгрөг хуваарилагдсан байна. Үүнээс нийт 17.1 тэрбум төгрөгийн вакцин, биобэлдмэл, зүү тариурын худалдан авалтыг санхүүжилтийг хуваарийн дагуу шилжүүлсэн ба томуугийн вакцинд 4.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгоод байна. | I-IV улирал | 100% |
| 1.2.17 | МУТЖҮЧ-2.2.2<br><br>Хүн амыг зонхилон тохиолдох халдварт бус өвчнийг эрт илрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна. | Тогтоолын шийдвэрийн дугаар<br><br>Хамруулсан хүний тоо, зарцуулсан мөнгөн дүн | 36,787.1 сая төгрөг | Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн дагуу санхүүжүүлсэн байна. | Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/150 дугаар тушаалаар урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, оношилгоо, шинжилгээг эрчимжүүлэх чиглэлээр 1.3 тэрбум төгрөгийн төсвийг батлуулсан. Тус тушаалын дагуу 868.7 сая төгрөгийн санхүүжилтийг УНТЭ, УХТЭ, УГТЭ, ЦТЭ-үүдэд олгоод байна. | I-IV улирал | 100% |
| 1.2.18 | Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулга (нэмэлт, өөрчлөлт)-ын төсөл боловсруулж батлуулна. | Нэмэлт өөрчлөлт оруулахаар өгсөн саналын тоо | Ажлын хэсэг байгуулагдсан. | Хамаарах чиг үүргийн саналыг өгсөн байна | Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулагдаагүй. | I-IV улирал | 0% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2.19 | ЗГҮАХ 2.1.7:5. Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сан байгуулна. | Эрсдэлийн сангийн хэмжээ | 40,000 сая төгрөг | Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн санг даатгалын санхүүжилтийн 9 хувь (51,4 тэрбум)-иар байгуулсан байна.. | ЭМД-ын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-д заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулиар 53,6 тэрбум төгрөг буюу нийт батлагдсан төсвийн 2,8%-иар Эрсдэлийн санг байгуулсан. ЭМДҮЗ-өөр хэлэлцүүлэн батлуулж, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан "Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сангийн хөрөнгийг тооцох, төрийн санд байршуулах, зарцуулах" журмын дагуу Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн жилд үүссэн нөхцөл байдалд үндэслэн тусламж үйлчилгээний санхүүжилт, тоо хэмжээ нэмэгдсэнтэй холбоотойгоор Эрсдэлийн сангийн хөрөнгийг зарцуулах шийдвэрийг ЭМДҮЗ-ийн 2024 оны 15 дугаар тогтоолоор батлуулан зарцуулсан. 2025 оны төсвийн төсөлд нийт нийт төсвийн 5 хувьд хүргэх буюу 124.7 тэрбум төгрөгт хүргэх саналыг Монгол Улсын Их Хурал, Сангийн яам, Үндэсний аудитын газарт 1а/3042 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | I-IV улирал | 100% |
| 1.2.20 | ЗГҮАХ 2.1.7.3<br><br>Урт хугацааны тусламж, үйлчилгээний загвар гаргаж, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудаар гүйцэтгүүлэн Улсын төсөв (ЭМДС)-өөс санхүүжүүлнэ. | Батлагдсан урт хугацааны тусламж, үйлчилгээний загвар,<br><br>Урт хугацааны тусламж, үйлчилгээнд улсын төсөв (ЭМДС)-өөс | Туршилтын төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө батлагдсан. | Урт хугацааны тусламж, үйлчилгээний загвар гарч, 20 хувийг Улсын төсөв (ЭМДС)-аас санхүүжүүлсэн байна. | Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/511 дүгээр тушаалаар "Эмнэлгийн урт хугацааны тусламж, үйлчилгээний загвар" боловсруулах ажлын хэсгийг байгуулж, загварын хувилбаруудын төслийг боловсруулж, ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн ч дахин боловсруулалт хийх шийдвэр гарсан.<br><br>Хууль эрхзүйн орчныг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага байгаа бөгөөд Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нэр томъёоны тодорхойлолт, тусламж, үйлчилгээний нэр төрлийн шинэ заалтууд оруулахаар 2024 | I-IV улирал | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | санхүүжүүл[illegible]-сэн хэмжээ | | | оны 04 дүгээр сард БТГ-т саналыг хариуцсан мэргэжилтэнд хүргүүлсэн.<br><br>Урт хугацааны тусламж, үйлчилгээг дэмжих зорилгоор Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны 08 дугаар тогтоолоор баталсан оношийн хамааралтай бүлгийн жагсаалтад дагнасан сэргээн засахын тусламж, үйлчилгээний 12 оношийн хамааралтай бүлэг үүсгэсэн бол 2024 оны 06 тогтоолоор 9 ОХБ болгож бууруулсан байна. Төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд сонгон шалгаруулалтын үндсэн дээр ЭМДЕГ-тай гэрээ байгуулж, иргэн даатгуулагчдад тусламж, үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлсэн.<br>ЭМДҮЗ-ийн 2023 оны 08 дугаар тогтоолыг шинэчлэж, 2024.03.29-ны өдөр "Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" 06 дугаар тогтоолыг баталсантай холбогдуулан Дагнасан сэргээн засах тусламж, үйлчилгээний амбулаторийн үзлэг 20,800 төгрөг, өдрийн эмчилгээ 223.600-410.800 төгрөг, хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ нь 812.600-1.300.000 төгрөгөөр ЭМДС-аас санхүүжиж байна.<br>2024 оны 11 дүгээр сарын байдлаар Эрүүл мэндийн даатгалын сангаас Дагнасан сэргээн засахын тусламж, үйлчилгээнд 11.8 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. | | |
| 1.2.21 | ЗГҮАХ 2.1.5.7<br><br>Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах лавлагаа төвийн чадавхийг | Байгуулагдсан Нийгмийн эрүүл мэндийн төвийн тоо | 2023 оны жилийн эцсийн байдлаар 10 аймгийн эрүүл мэндийн газрын бүтцэд | 10 аймаг, 3 дүүрэгт нийгмийн эрүүл мэндийн төв байгуулахтай холбоотой төсвийн тооцооллыг гаргаж төсвийн | Эрүүл мэндийн бодлого, удирдлага болон нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх чиг үүрэг бүхий эрүүл мэндийн газар байхгүй хүн амын суурьшил, нягтаршил өндөр 8 дүүрэг (Багахангай дүүргээс бусад) болон Аймаг бүрт Нийгмийн эрүүл мэндийн төв шинээр байгуулахад шаардагдах үйл ажиллагааны урсгал зардлын төсвийг 27.4 тэрбум төгрөгөөр | II-IV улирал | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нэмэгдүүлж, аймаг, дүүрэгт Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулна. | | нийгмийн эрүүл мэндийн төв нэртэй нэгж байна. | төсөлд тусгасан байна. | тооцон саналыг Монгол Улсын [illegible] Хурал, Сангийн яам, Үндэсний аудитын газарт 1а/3042 дугаар албан бичгээр хүргүүлсэн бөгөөд эрх зүйн орчин бүрдээгүй тул дэмжигдээгүй. Иймд "Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ, санхүүжүүлэх, төлбөртэй тусламж, үйлчилгээний төрөл, орлого, хандив тусламжийг зарцуулах журам" боловсруулах ажлын хүрээнд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцын дагуу өртөг, төлбөрийн аргыг тодорхойлох, дагалдах тооцооллуудыг зөвлөхүүдийн хамт хийсэн ба 2024 оны 11 сарын 15-ны өдөр Эрүүл мэндийн яамны сайт дээр тушаалын төслийг байршуулан олон нийтээс санал авч байна. | | |
| 1.2.22 | ЗГҮАХ-2.1.13.2 Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний багцыг оновчтой болгож, гүйцэтгэлийн шалгуурын дагуу тусламж, үйлчилгээ, иргэнийг дагасан гүйцэтгэлийн санхүүжилтийг нэвтрүүлэх | Гүйцэтгэлийн санхүүжилт нэвтэрсэн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв тоо, тусламж үйлчилгээний багцын тоо, олгосон санхүүжилт | 2023 оны ЭМДҮЗ-ийн 6 дугаар тогтоолоор хэрэгжиж байна. | Анхан шатны тусламж, үйлчилгээний багц, нэр төрлийг өргөжүүлсэнтэй холбоотойгоор холбогдох тооцооллыг хийж журамд тусгах, санхүүжилтийг гүйцэтгэлийн дагуу санхүүжүүлэх | ЭМДҮЗ-ийн 2022 оны 05 дугаар тогтоол, 2023 оны 06 дугаар тогтоол батлагдаж, хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой анхан шатны тусламж, үйлчилгээг цахимжуулах ажлыг эхлүүлж, гүйцэтгэлийг тогтмол үнэлж, санхүүжилтийг олгодог тогтолцоо хэрэгжиж эхэлсэн.<br><br>ЭМД-ийн сангийн 2024 оны төсвийн тухай хууль, МУЗГ-ын 2023.06.21-ны өдрийн "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 241 тогтоол батлагдаж, анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын тусламж үйлчилгээг оновчтой, хүртээмжтэй, үр дүнд суурилсан гүйцэтгэлийн санхүүжилтийг хэрэгжүүлж буй багц, төлбөрийн арга, журам, зохицуулалтад зарим нэг бодлогын тохируулга хийх, түүнчлэн 2024.04.01-ны өдрөөс цалин хөлс, орон нутгийн нэмэгдэл олгох зэргийг үндэслэн ЭМДҮЗ-ийн 06 дугаар тогтоолд | I-IV улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | өөрчлөлт оруулах ажлын хүрээнд Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/400 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсэгт ажиллаж, 2024.03.29-ны 05 дугаар Анхан шатны тусламж, үйчилгээний "Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" тогтоол батлагдан, 2024.04.01-ны өдрөөс хэрэгжиж байна.<br><br>Түүнчлэн анхан шатны тусламж, үйлчилгээгээр 2024.01.01-ний өдрөөс нийт 546 эрүүл мэндийн байгууллага гэрээ байгуулан ажиллаж байгаагаас 328 сум, тосгоны эрүүл мэндийн төв, 218 өрхийн эрүүл мэндийн төв байна.<br><br>Мөн ЭМДСангийн төсвийн нарийвчилсан хуваариар Анхан шатны тусламж, үйлчилгээнд 2024 онд нийт 455.1 тэрбум төгрөг зарцуулахаар баталсан бөгөөд 2024 оны эхний 11 сарын байдлаар нийт 267.2 тэрбум төгрөгийг зарцуулаад байна.<br>Шинэчилсэн 06 дугаар тогтоолын хүрээнд дараах 4 өөрчлөлтийг оруулсан. Үүнд: | | |
| | | | | | 1. МУ 2024 оны төсвийн тухай хуулийн дагуу орон нутгийн өрхийн эрүүл мэндийн төвүүд болон сум тосгоны эрүүл мэндийн төвийн албан хаагчдын ЗГ-аас баталсан үндсэн цалинг 10, 20 хувиар өсгөж, орон нутгийн нэмэгдлийг 20, 40 хувиар олгохтой холбоотойгоор тооцооллыг цалингийн тохируулга хэсэгт тусгасан.<br>2. Хүүдийн өдрийн эмчилгээний багцыг шинээр үүсгэж, анхан шатандаа өдрийн эмчилгээг өргөжүүлэн, хүртээмжтэй авах боломжийг бүрдүүлсэн. Гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээний багцыг өргөжүүлэн, Оношилгоо шинжилгээний зардлыг сард 40.0 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мянган төгрөгийн өөрсдөөс хэтрүүлэхгүйгээр нэхэмжилж болох зохицуулалтыг тусгасан.<br><br>3. Сүрьетэй өвчтгүүдэд амбулаториор эмийг харж уулгах үйлчилгээг ойртуулах зорилгоор хяналтын үзлэгийн багцыг анхан шатны ЭМБ-ыг санхүүжүүлэхээр төлөвлөсөн ба хөнгөвчлөх тусламж үйлчигээг сайжруулах үүднээс анхан шатны ЭМБ санхүүжүүлэхээр төлөвлөсөн. | | |
| | УИХ-ын 23 дугаар тогтоолын 2.2.1 ЗГҮАХ 2.1.1.5 МУХТЖҮЧ 2.2.2 МУХТ 1.3.1 ЭМССТ 1.15 “Элэг бүтэн монгол” арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | 2023 оны арга хэмжээний хэрэгжилт 54.3 хувьд хүрсэн байна. | 2024 онд төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна. | Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/577 дугаар “Элэг бүтэн Монгол” арга хэмжээний төлөвлөгөөг 2022-2024 онд хэрэгжүүлэхээр баталж, 2024 онд 4 зорилтын хүрээнд 34 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Эрүүл мэндийн 2024 оны батлагдсан төсөвт “Элэг бүтэн Монгол” арга хэмжээний зардалд 7.4 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд ЭМС-ын А/345 дугаар тушаалаар Д вирустай иргэдийн эмчилгээнд 4,3 тэрбум төгрөг шилжүүлжсэн байна. | I-IV улирал | 100% |
| 1.2.23 | МУХТЖҮЧ-2,2,2, ЗГҮАХ-2,1,1,<br><br>МУХТ 1,3,1 “Элэг бүтэн Монгол” арга хэмжээг хэрэгжүүлж, Д вирустай иргэдийг эмчилгээнд хамруулна. | Арга хэмжээний нэр, төрөл зарцуулсан мөнгөн дүн | Арга хэмжээний төлөвлөгөө батлагдсан. | Холбогдох санхүүжилтийг гүйцэтгэлийн дагуу хянаж олгосон байна. | ЭМС-ын 2023 оны А/362 дугаар тушаалаар “Элэг бүтэн Монгол” арга хэмжээний хүрээнд гепатитын B, D вирусын халдвартай иргэдэд олгох эмийн зардалд 9.7 тэрбум төгрөг, 2024 онд 7.3 тэрбум төгрөг батлагдсан. 2023 оны санхүүжилтийн үлдэгдлээс 2.3 тэрбум төгрөгөөр 11640 ширхэг пэгинтерферон альфа -2а эмийг худалдан аваад байна. Мөн Монгол Улсын Их Хурлын байнгын хорооны 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн хуралдааны 04 дүгээр тогтоолд гепатитын B, D вирусын халдварын тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэх, эмчлэх зорилгоор тодорхой арга хэмжээг авах чиглэлийг Засгийн газарт өгөхөөр хэлэлцэн баталсан ба Монгол Улсын Засгийн газрын 2024 онд “Гепатитын B, D вирусын халдварын талаар | I-IV улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | авах арга хэмжээний тухай" тогтоол батлагдаад байна. Үүнтэй холбоотойгоор ЭМС-ын 2024 А/345 дугаар тушаалаар 4.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгоод байна. | | |
| 1.2.24 | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын 36.1.2, 36.4 дэх заалт. "Олон улсын чанарын шаардлага хангасан хүний эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, вакциныг гадаад улсын үйлдвэрлэгчээс, эсхүл олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах" журам боловсруулна. | Засгийн газрын тогтоол | - | Журам Засгийн газрын тогтоолоор батлагдсан байна. | "Олон улсын чанарын шаардлага хангасан хүний эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, вакциныг гадаад улсын үйлдвэрлэгчээс, эсхүл олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах" журмын төслийн санхүүжилтийн 4 дүгээр бүлэг "Санхүүжилт" хэсгийг боловсруулалт хийж, удирдлагад танилцуулж, Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлэн журмын төсөлд тусгуулсан. /Засгийн газрын 2024 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан./ | I улирал | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2.25 | Салбарын 3 талт хэлэлцээрийн хэрэгжилтийг дүгнэж шинэчлэн батална. | Хэлэлцээр ийн хэрэгжилтийн тайлан, Шинээр батлагдсан 3 талт хэлэлцээр | 2021-2023 оны хэлэлцээр хэрэгжсэн байна. | Салбарын 3 талт 2024-2026 оны хэлэлцээрийг байгуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | Салбарын 3 талт хэлэлцээрийн 2023 оны хэрэгжилтийг дүгнэх, шинэчлэн батлагдахтай холбоотойгоор Эрүүл мэндийн салбарын албан хаагчдын цалин хөлс, нийгмийн баталгааны талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай тайланг боловсруулан удирдлагад танилцуулж, Төрийн захиргааны удирдлагын газарт хүргүүлэн тайланд тусгуулж ажилласан. Боловсруулсан тайлан болон саналын тоо 2. | I-IV улирал | 100% |
| 1.2.26 | Удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулна. | Үйл ажиллагаа ны тайлан | - | Удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулсан байна. | Удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулахад шаардагдах мэдээ, мэдээллийг Эмнэлгийн тусламж үйлчилгээний газар, Бодлого төлөвлөлтийн газарт тухай бүр хүргүүлэн ажилласан. Мөн зөвлөгөөнтэй холбоотой гарах зардлын тооцооллыг хийж, 2024 оны төсвийн хуваарийн өөрчлөлтөөр зохицуулалт хийх саналыг 2024.04.01 1а/1289, 2024.10.14 1а/4183-ны албан бичгээр төсөвт зохицуулалт хийх саналыг Сангийн яаманд хүргүүлж шийдвэрлүүлэн Удирдах ажилтны зөвлөгөөнийг 2 удаа амжилттай зохион байгуулсан байна. | I улирал | 100% |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дуусcан хугацаа | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1.<br>Чиг үүргийн дагуу ажлын хэсэг, үнэлгээний хороонд ажиллах. | Үүрэг даалгавар биелэгдсэн байна. | - | Үүрэг даалгавар биелэгдсэн байна. | Улсын нэгдүгээр төв эмнэлгийн гадаад пасадны засварын тендер, Дэлхийн банкны Монгол улсад Ковид 19-ийн халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төслийн 2 ажилтан сонгон шалгаруулах ажлын хэсэг, АХБ-ны төслийн 2 мэргэжилтэн сонгон шалгаруулах ажлын хэсэг, Дарханы нэгдсэн эмнэлгийн Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудыг сонгон шалгаруулах ажлын хэсэгт мөн ЭМЯ- | I-IV улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ны орон нутагт шаардлагатай автомашин болон тоног төхөөрөмж худалдан авах 4 үнэлгээний хорооны даргаар тус тус ажилласан. | | |
| 2 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлд ажиллах. | Үүрэг даалгавар биелэгдсэн байна. | - | Үүрэг даалгавар биелэгдсэн байна. | УНТЭ-н ТУЗ-н даргаар томилогдон 2023 оны 7 дугаар сараас хойш 4 удаа 2024 онд ТУЗ-н хурлыг 5 удаа хийж эмнэлгийн хэвийн үйл ажиллагааг хангаж байна. | I-IV улирал | 100% |
| 3 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3. Дэлхийн банкны Монгол улсад Ковид 19-ийн халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төслийн захирлын үүрэг гүйцэтгэх. | Үүрэг даалгавар биелэгдсэн байна. | - | Үүрэг даалгавар биелэгдсэн байна. | Дэлхийн банкны Монгол улсад Ковид 19-ийн халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төслийн захирлаар ажиллаж байна. Төслийн удирдах хорооны хурлыг хийж 2024 оны төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | I-IV улирал | 100% |
| 4 | Эрүүл мэндийн яамны ёс зүйн дэд хорооны даргаар ажиллах | Яаманд төрийн албаны шинэтгэл, Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах | | Хуулийн хэрэгжилт хангагдсан байна. | 2024 оны 5 сараас байгууллагын ёс зүйн дэд хороонд орж ажиллан ёс зүйн дэд хорооны даргаар томилогдон ёс зүйн хорооны 2024 оны хийх ажлын төлөвлөгөөг батлан хорооны хурлыг 6 удаа хийж ирсэн 5 өргөдөл, гомдлыг шийдвэрлэн ажиллаж байна. | I-IV улирал | 100% |

## ХОЁР. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Худалдан авах ажиллагааны сургалтад хамрагдаж А3 сертификат авах. | Гэрчилгээ | | Гэрчилгээ авсан байх | Худалдан авах ажиллагааны сургалтад хамрагдаж А3 сертификат авсан | I-IV улирал | 100% |
| 2 | Эрхэлсэн ажлын хүрээнд сургалт, хурал зөвлөгөөнд оролцох. | Сургалт, хурал зөвлөгөөний тоо | | Зөвлөгөөнд оролцсон байна. | - Эрүүл мэндийн яамнаас албан хаагч нартаа зориулан зохион байгуулсан цахим болон танхимын сургалтуудад амжилттай хамрагдсан.<br>- Төрийн албаны зөвлөлөөс төрийн албан хаагчийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулдаг сургалт.<br>- Эрүүл мэндийн яамны Ёс зүйн дэд хорооноос зохион байгуулсан сургалт.<br>- Процессын дахин инженерчлэлийн ажлын хэсэгт Сэтгэл судлал, хүний нөөцийн удирдлагын сургалт.<br>- Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар, Цагдаагийн Ерөнхий газрын Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газруудаас зохион байгуулсан танхимын сургалтад тус тус амжилттай хамрагдсан.<br>- АТГ-аас зохион байгуулсан авлигын эсрэг 2 төрлийн сургалтад хамрагдсан<br>- Мөн Сангийн яамнаас зохион байгуулсан дараах сургалтуудад суусан.<br>- - төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн сургалт<br>- - Ногоон санхүүгийн зохицуулалтын хүрээний сургалт<br>- - Засгийн газрын гадаад зээл тусламжийн хөрөнгийг ашиглах, эдгээр | I-IV улирал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах журмын өөрчлөлтийн уулзалт хэлэлцүүлэг гэх мэт хурал зөвлөгөөнд оролцлоо. | | |

*Төлөвлөгөөг үнэлсэн:* ***Төсвийн шууд захирагч***

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА .............................. /Д.ОЧИРБАТ/

*(албан-тушаал)* *(гарын үсэг)*

*(огноо)*

*Тэмдэг*

............................

*Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:* ***Нэгжийн дарга***

................................................... ......................... /............................../

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

*(огноо)*

...............................

*Тайлагнасан:* ***Нэгжийн дарга***

Санхүү, эдийн засгийн бодлогын газрын дарга / Л.ЛУВСАН /

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

............................ *(огноо*